| Нэмж гаргах хувьцааны тоо | 33,859,363.00 | 6,263,982,155.00 | 185.00 |
| Нийт | 99,586,363.00 | 20,024,761,455.00 | 201.08 |

Хүснэгт 15. Дансны үнийн өөрчлөлт

МОНГОЛ ШУУДАН ТӨХК УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК GAULI SECURITIES Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ

GAULI INVESTMENT SECURITIES

# НЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Нэгж хувьцааны цэвэр хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт

Төгрөг

| Үзүүлэлт | Хувьцааны тоо | Цэвэр хөрөнгийн үнэ цэнэ | Дансны үнэ |
|---|---|---|---|
| 2015.09.30-ны байдлаар | 65,727,000.00 | 17,282,278,260 | 262.46 |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 33,859,363.00 | 6,263,982,155.00 | 185.00 |
| Нийт | 99,586,363.00 | 23,546,260,415.00 | 236.44 |

Хүснэгт 16. Нэгж хувьцааны цэвэр хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт

Зах зээлийн жишиг үнийн аргаар тооцсон бизнесийн үнэ цэнийн өөрчлөлт

Төгрөг

| Үзүүлэлт | Хувьцаа тоо | Зах зээлийн жишиг үнэ | Нэгжийн үнэ цэнэ |
|---|---|---|---|
| 2015.09.30-ны байдлаар | 65,727,000.00 | 17,176,642,760.00 | 261.33 |
| Нэмж гаргах хувьцаа | 33,859,363.00 | 6,263,982,155.00 | 185.00 |
| Нийт | 99,586,363.00 | 23,440,624,915.00 | 235.38 |

Хүснэгт 17. Зах зээлийн жишиг үнийн аргаар тооцсон бизнесийн үнэ цэнийн өөрчлөлт

Үнэт цаас гаргасны дараах үеийн компанийн "дансны үнэ" болон "нэгж хувьцааны цэвэр хөрөнгийн үнэ цэнэ", "зах зээлийн жишиг үнийн аргаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнэ" харгалзан 201.08 төгрөг, 236.44 төгрөг, 235.38 төгрөг байна. Эдийн засгийн хямралтай, хөрөнгийн зах зээл уналттай үед хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй байдаг учраас олон нийтэд санал болгох үнийг хөрөнгө оруулагчдын худалдан авах боломжит үнэд хүргэх нь хөрөнгө босгох үйл ажиллагаа амжилттай болоход чухал нөлөөтэй. Иймд санал болгож буй үнийг 185 төгрөгөөр тогтоосон нь нэг талаас улсын эдийн засаг хүндэрсэн/2015 оны эцэст 2%-3%-ийн өсөлт, төсвийн алдагдал 1 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна/, гадаадын хөрөнгө оруулалт буурсан/сүүлийн нэг жилийн хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ хасах дүнтэй байна/, дотоодын хөрөнгө оруулагчдын чадавхи муудсан/компаниудын төлбөрийн чадвар муудсан нь банкны чанаргүй зээлийн хэмжээ 1.7 их наядад хүрч нийт зээлд эзлэх хувь 15 хувьд хүрсэнээр харагдаж байгаа бол иргэдийн худалдан авах чадвар муудсан нь худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийн удаашрал болоод банкны хадгаламжийн өсөлтийн удаашралаас тод харагдаж байна/ өнөөгийн нөхцөлд бодит үндэслэлтэй гэж үзэж байна.

Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжах үнийг андеррайтер, үнэт цаас гаргагч нар хамтран тогтоох болно. Үнэт цаасыг захиалгын бүртгэлийн аргаар олон нийтэд санал болгох үнийг эцэслэн тогтоохдоо худалдан авахаар ирүүлсэн нийт захиалгын жигнэсэн дундаж үнэ, үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөсөн хөрөнгийг бүрэн бүрэлдүүлэх боломжит үнэ, аль болох олон этгээдийн захиалга биелүүлэх боломжит үнэ зэргийн харгалзан үзэх болно.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ

## 2.1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Схем 2. Компанийн бүтэц, зохион байгуулалт

СЗХ
Он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагч компанийн дүрмийн 1.4-д тус компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага байна хэмээн заажээ. Иймд Төрийн өмчийн хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байна.

"Монгол Шуудан" компани нь 2008 оны 04 сарын 17-ны өдрийн Төрийн Өмчийн Хорооны ""Монгол Шуудан" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг өөрчлөн байгуулах тухай" 231 тоот тогтоолоор "Хувьцаат компани"-ийн статустай болон өөрчлөгдөж дүрмэндээ өөрчлөлт оруулжээ.

| Компанийн нэр | Хувийн эзэмшил | Төрийн эзэмшил | Хэлбэр |
|---|---|---|---|
| "Монгол Шуудан" | 0% | 100% | ТӨХК |

Хүснэгт 20. Хувьцаа эзэмшигч

## 2.1.6 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1-д зааснаар Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад, гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно гэсний дагуу дараах байдлаар мэдээлж байна.

### I. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Албан тушаал | Овог нэр | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ын дарга | О. Сэр-Од | Үгүй |
| 2 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Б.Амарсанаа | Үгүй |
| 3 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Л. Оюун | Үгүй |
| 4 | ТУЗ-ын хараат бус гишүүн | Б. Мөнхбаяр | Үгүй |
| 5 | ТУЗ-ын гишүүн | Д.Болдмягмар | Үгүй |
| 6 | ТУЗ-ын гишүүн | Д. Нарангэрэл | Үгүй |
| 7 | ТУЗ-ын гишүүн | Ч. Даваажамц | Үгүй |
| 8 | ТУЗ-ын гишүүн | Д. Дэлгэрмаа | Үгүй |
| 9 | ТУЗ-ын гишүүн | Б. Мөнхтулга | Үгүй |
| 10 | ТУЗ-ын нарийн бичиг | Б. Цолмон | Үгүй |

Хүснэгт 21. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## II. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ХЭЛТЭС БОЛОН АЛБАДЫН ДАРГА НАР, ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Овог нэр | Албан тушаал | Хувьцаа эзэмшдэг эсэх |
|---|---|---|---|
| 1 | Ц. Батсайхан | Гүйцэтгэх захирал | Үгүй |
| 2 | А. Шарав | Тэргүүн дэд захирал | Үгүй |
| 3 | Б. Уянга | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | Үгүй |
| 4 | Б. Цэцэндаваа | Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга | Үгүй |
| 5 | Ө. Сугар | Санхүүгийн хэлтсийн дарга | Үгүй |
| 6 | Б.Содчимэг | Шуудангийн ашиглалт, технологийн газрын дарга | Үгүй |
| 7 | Д. Ганболд | Маркийн газрын дарга | Үгүй |
| 8 | Д. Туваан | Дотоод хяналтын албаны дарга | Үгүй |
| 9 | А. Жаргал | Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга | Үгүй |
| 10 | Б. Бат-Өлзий | Хангамж үйлчилгээний албаны дарга | Үгүй |

Хүснэгт22. Удирдах албан тушаалтнуудын мэдээлэл

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 11

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

"Монгол Шуудан" ТӨХК нь Монгол улсын бүх аймаг хотын төв дэх 21 Шуудан Үйлчилгээний Газар /ШҮГ/, сумдын 334 шуудан үйлчилгээний салбар /ШҮС/ нийслэл Улаанбаатар хот дахь 40 шуудангийн үйлчилгээний салбарт нийт 895 ажиллагсадтайгаар шуудан холбооны 20 төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэн явуулж байгаа Монгол улсын шуудангийн үйлчилгээний анхдагч байгууллага юм. "Монгол Шуудан" ТӨХК нь Монгол улсын засаг захиргааны нэгж болох нийт багийн 77 хувьд шуудангийн үндсэн үйлчилгээ үзүүлдэг 100 хувь "Төрийн өмчит" А ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч компани билээ.

### "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК-ИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тус компани нь шуудангийн үйлчилгээний технологийн чанартай, найдвартай, шуурхай байдлыг хангах, дэлхийн шуудангийн үйлчилгээний технологийн хөгжилд хөл нийлүүлэх үүднээс өөрийн компанийн хүчин чадал болон хамтын ажиллагаатай гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудын шуудангийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан дараах томоохон программ хангамжийг нэвтрүүлэн ашиглаж байна. Үүнд:

- Олон улсын шуудан холбооны гадаад шуудан бүртгэл, тооцооллын IPS Light систем
- Гадаад болон дотоод шуудангийн солилцоо, бүртгэлийн Postnet систем
- Veritech Санхүү бүртгэл, агуулахын шинэ программ хангамж
- Veritech/HRM Хүний нөөцийн программ хангамж
- Хэвлэлийн захиалга нэгтгэлийн Orders Pro программ

Түүнчлэн Монгол шуудан ТӨХК-ны төв аппарат болон Маркийн газар, Улаанбаатар хотын 22 салбар, нэгж 2013 оноос бүх аймгийн төвийн ШҮГ-ууд хоорондоо өндөр хурдны нэгдсэн мэдээллийн сүлжээнд /шилэн кабелаар/ холбогдон 24 цагийн турш үйлдвэрлэлийн боловсруулалт гүйцэтгэх, интернэт ашиглан гадаад шуудангийн бүртгэл, лавлагааг хийх болсон. Аймгийн ШҮГ-ууд, УБ хотын салбар, нэгжүүд болон компанийн захиргаанаас 200-гаад компьютер ашиглан, мэдээ тайлангийн солилцоог тус тусын сүлжээгээр дамжуулан файлаар /электрон хэлбэрээр байгууллагын дотоод мессенжер болон мэйл ашиглан/ солилцож байна.

Өнөөдрийн байдлаар улс, хот хоорондын шууданг долоо хоногт 2-5 удаа, аймгийн төв, сум хооронд долоо хоногт 1-3 удаа, сумаас 1200 гаруй багт 7 хоногт 1 удаа хүргэж, дэлхийн 200 гаруй оронтой шуудан солилцож байна. Мөн шуудангийн хамгийн шуурхай хэлбэр болох буухиа шуудан \EMS\-г дэлхийн 35 оронтой солилцон ажиллаж байна.

Шинэчлэлийн Засгийн Газрын дэмжлэгтэйгээр 2013 оноос хот хоорондын ачаа тээврийн үйлчилгээг нэвтрүүлж, хот хоорондын өөрийн шуудангийн сүлжээг бий болгохоор ажиллаж байгаа ба төрийн байгууллагуудтай хамтран "Төрийн түгжрэлгүй үйлчилгээ"-г бодитоор бий болгох ажилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Мөн дэлхийн шуудангийн үйлчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхээр "Ухаалаг шуудангийн хайрцаг" төслийг нэвтрүүлж, 20 байршилд 1000 ширхэг нүд бүхий ухаалаг шуудангийн хайрцгийг байршуулан үйлчилгээг үзүүлж, сүлжээгээ өргөтгөсөн.
Энэ нь Монголын шуудангийн үйлчилгээ шинэчлэгдэн хөгжиж буйн нэг гол илрэл юм.

GAULI SECURITIES
УЛААНБААТАР ХОТ
20151211

СЗХ БҮРТГЭВ № 01

GAULI INVESTMENT SECURITIES

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## КОМПАНИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

"Монгол Шуудан" ТӨХК нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Компанийн дүрмээс гадна ОУ-ын холбогдох конвенциудыг удирдлага болгон мөрдөн ажилладаг.

**Үүнд:**

01. Монгол улсын үндсэн хууль /1992 он/
02. Монгол улсын иргэний хууль /2002 он/
03. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/
04. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005/
05. Компанийн тухай хууль /2011 он/
06. Үнэт цаасны тухай хууль /2013 он/
07. Шуудангийн тухай хууль /2003 он/
08. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль /2005 он/
09. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2001 он/
10. Аудитын тухай хууль /1997 он/
11. Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/
12. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2015 он/
13. "Монголын компанийн засаглалын кодекс"

"Монгол Шуудан" ТӨХК нь дараах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд "Одгэрэл энд Партнерс" өмгөөллийн ХХН-ийн дүгнэлтэд: "Монгол Шуудан" ТӨХК нь тусгай зөвшөөрөл эзэмших хугацаандаа тусгай зөвшөөрлийн аливаа хууль, дүрэм, журам, нөхцөл шаардлага зөрчиж байгаагүй" хэмээн тодорхойлсон байна.

**Үүнд:**

**А ангиллын тусгай зөвшөөрөл**
Монгол улсын нутаг дэвсгэрт "Шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах"

**Б ангиллын тусгай зөвшөөрөл**
Улс хооронд болон Монгол улсын нутаг дэвсгэрт "Шуудангийн үйлчилгээ эрхлэх"
"Улс хоорондын шуудангийн логистик үйлчилгээ эрхлэх"

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Шуудангийн байгууллагын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримталж ажиллахыг хуулиар зааж өгсөн байдаг.

**Үүнд:**

Хууль дээдлэх.
Шуудангийн үйлчилгээ нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй, шуурхай байх.
Шуудангийн илгээмжийг саадгүй, чөлөөтэй илгээх.
Үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэх
Нийтийн шуудангийн үйлчилгээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тэгш эрхтэй оролцох.
Шуудангийн сүлжээний ажиллагаа тогтвортой байх.
Шуудангийн салбарт дагаж мөрдүүлэх стандарт, дүрэм нь харилцан уялдсан, нэгдмэл байх.

## КОМПАНИЙН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

"Монгол Шуудан" ТӨХК нь 1963 онд Дэлхийн Шуудан Холбооны Байгууллагад, 2000 онд Ази Номхон Далайн Шуудангийн Бүсийн байгууллагад албан ёсны гишүүнээр тус тус элссэн.
Компани тус олон улсын байгууллагад элссэнээс хойш 40 жилийн дараа буюу 2002 онд Дэд Бүтцийн Сайдын урилгаар тус ДШХБ-ын дэд захирал, 2003 онд ДШХБ-ын Ерөнхий Захирал Монгол улсад айлчилсан байдаг. Тус айлчлалын хүрээнд Монгол Улсын шуудангийн салбарын хөгжилд дэмжлэг болох үүднээс Олон Талт төсөл буюу 2 талын хөрөнгө оруулалтаар 3 төрлийн хөтөлбөртэй төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан байна.
Мөн Монгол Шуудангийн байнгын түнш болох ОХУ, БНХАУ, Япон, БНСАУ, АНУ, Их Британи, Франц, Энэтхэг, Тайланд зэрэг орнуудын шуудангийн байгууллагуудтай өнөөгийн түвшин дэх харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.
Дэлхийн 200 гаруй улстай, түүний дотор шуудангийн хамгийн шуурхай хэлбэр буюу буухиа шуудан 35 улстай солилцдог.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Тус компани нь холбогдох хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон үүргийн хүрээнд дараах үйл ажиллагаануудыг явуулахаар дүрмэндээ заажээ.

- Захидал, бичиг, боодол илгээлт зэрэг шуудангийн бүх үйлчилгээ, шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, борлуулах, гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах үүнтэй холбогдон үүсэх бусад ажил, үйлчилгээ явуулна.
- Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

Компани нь хууль эрх зүйн хүрээнд салбар нэгжүүдээрээ дамжуулан шуудан холбооны дараах нэр бүхий 20 нэр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлж байна.

**01** Албан байгууллага иргэдээс бичиг, захиа, боодол болон илгээлтийг хүлээн авч хүргэж гардуулах

**02** Шуудангийн тарифийн болон уран сайхны марк, үнэт цаасны эх зураг зохиох, хэвлүүлж гадаад, дотоодын зах зээлд борлуулах

**03** Шуудангийн хэрэглэгчийн, орцны, ухаалаг шуудангийн хайрцгаар үйлчлэх

**04** Буухиа шуудангийн үйлчилгээ

**05** Орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээ

**06** Дотоод, гадаадын тогтмол хэвлэл, номын захиалга хүлээн авах, хүргэж гардуулах

**07** Өргөн хэрэглээний бараа болон ном, сэтгүүл, эрэлт ихтэй барааг захиалгаар нийлүүлэх, гэрээгээр зарж борлуулах,

**08** Дугтуйны үйлдвэрлэл, худалдаа

**09** Аерограмм, экспресс, купоны үйлчилгээ

**10** Гардуулалтын картын үйлчилгээ

**11** Албан газар, айл гэрийн хүргэлт

**12** Бизнесийн байгууллагуудтай хамтран тэдний гэрээт төлөөлөгчөөр ажилладаг. /Даатгалын үйлчилгээ, тамга, принтерийн хор гэх мэт захиалга хүргэлт/

**13** Шуудан лавлагааны 1613 тусгай дугаарын үйлчилгээ

**14** Постмаркетинг үйлчилгээ

**15** EZpost үйлчилгээ

**16** Монгол марк, номын онлайн захиалга, хүргэлтийн үйлчилгээ

**17** Хот хооронд ачаа тээвэр, шуудангийн логистикийн үйлчилгээ

**18** Сонин хэвлэлийн эртийн хүргэлт, хот доторх илгээмжийн шууд хүргэлт үйлчилгээ

**19** Би илгээе...хүлээн авагч шуудангийн төлбөрийг нь төлөх нөхөн төлбөрт үйлчилгээ

**20** Социологийн болон зах зээлийн судалгааны материал цуглуулах үйлчилгээ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ
2015 12 11

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## "МОНГОЛ ШУУДАН" ТӨХК-ИЙН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

"Монгол Шуудан" ТӨХК нь 20 нэр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдгээс доорх 6 төрлийн үндсэн үйлчилгээнүүд нь орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг.

- Хэвлэл захиалга
- Албан бичиг хүргэлт
- Үнэт цаас, маркны борлуулалт
- Ачаа тээврийн үйлчилгээ
- Хүргэлтийн үйлчилгээ
- Илгээлт, буухиа шуудангийн үйлчилгээ

## ХЭВЛЭЛ ЗАХИАЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

### Дотоод хэвлэл захиалга

"Монгол шуудан" ТӨХК нь 100% төрийн өмчтэй, шуудангийн үндсэн сүлжээг эзэмшигчийн хувьд хот, хөдөөгийн нийт шуудангийн салбараараа дамжуулан 320 гаруй нэр төрлийн сонин, сэтгүүлийг улирал бүр 100-150 мянган хэрэглэгчдээс захиалга авч, шуудангийн хайрцаг, ажлын болон гэрийн хаягаар хүргэж үйлчилдэг.

Энэхүү үйлчилгээн нь жил бүр алдагдалтай гардаг бөгөөд үүнд нөлөөлдөг гол хүчин зүйл нь сонин хэвлэлийг захиалагчдад нь түргэн шуурхай хүргэж үйлчлэхэд зарцуулж буй шатахуун, сэлбэг, цалин гэх мэт ашиглалтын зардал юм.

- Компанийн нийт орлогын 10%-ийг хэвлэлийн шимтгэл болон жингийн орлого эзэлдэг.
- УБ-аас аймагт, аймгаас сумд явж буй нийт шуудангийн жингийн 80-90 хувийг хэвлэл сонин эзэлдэг.
- Орон нутагт явж буй нийт хэвлэлийн жингийн 25-30 хувь нь агаараар, бусад нь газраар тээвэрлэгддэг.

## СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН ДОТООД ХЭВЛЭЛ ЗАХИАЛГЫН ДҮН




График 4: Дотоодын хэвлэл захиалгын дүн

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ГАДААД ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА

ОХУ-ын шуудангийн байгууллагатай хамтран 200 гаруй нэр төрлийн Орос, Англи хэл дээрх хэвлэлийн захиалгыг Монгол орон даяар авч, хүргэж үйлчлэх үйлчилгээг олон жил үзүүлсээр ирсэн. Гадаад хэвлэл захиалгын үйлчилгээг орон даяар "Монгол шуудан" ТӨХК дангаараа, харин Улаанбаатар хотод УБ шуудан, Түгээмэл шуурхай шуудан, Скай шуудан, Роял пост зэрэг шуудангийн байгууллагууд үзүүлж өрсөлдөөнт зах зээлийн орчинг үүсгээд байгаа ба зах зээлийн эзлэмжийн хэмжээг судалгааны үндсэн дээр авч үзвэл:




График 5: Гадаад хэвлэл захиалгын зах зээлийн эзлэх хувь

2013 онд гадаад хэвлэл захиалгын үйлчилгээг үзүүлэх давуу эрх, тусгай зөвшөөрлөө баталгаажуулан, Улаан-Үд-ийн шуудангийн байгууллагатай байгуулах гэрээгээ шинэчлэн байгуулж, давтамжийг 7 хоногт 2 удаа байсаныг 3 удаа болгон, хүргэлтийн хугацааг богиносгож журамласан байна.

## ГАДААД ХЭВЛЭЛ ЗАХИАЛГЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ӨСӨЛТ \САЯ.ТӨГ\




График 6: Гадаад хэвлэл захиалгын шимтгэлийн орлогын өсөлт

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ГАДААД ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА

Хэвлэл захиалгын үйлчилгээг идэвхижүүлэх, захиалгын тоог нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлд анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Үүнд:**

- Аймгаас сумдад хэвлэл шуудан, зорчигч тээвэрлэхэд зориулж, автомашины парк шинэчлэлтийг хийх
- Төрийн ТҮЦ машинаар дамжуулж бүх төрлийн хэвлэлийг захиалдаг болох
- Нэг сайтаас бүх төрлийн хэвлэлийн цахим захиалгыг хийдэг болох
- Жинд суурилсан тарифийг нэмэгдүүлж, мөрдөх
- Гэрээт хүргэгчийг нэмэх
- Хэвлэлийн хүргэлтийн хугацааг богиносгох
- Хэвлэл захиалгын үйлчилгээний танилцуулга, тараах материал гаргах
- Монголд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компани болон оршин сууж байгаа гадаад иргэдийн судалгаа гаргаж захиалгын үеэр санал, гарын авлага, танилцуулга хүргүүлэх
- Байнгын захиалагч нартаа урамшуулал олгох

## ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ



"Монгол шуудан" ТӨХК нь одоогоор нийт

**37,271**

ширхэг шуудангийн хайрцагтай Үүнээс

**2081** орцонд байрлуулсан

**20329**-ийг хувь хүн эзэмшиж байна

**11949** хайрцаг эзэнгүй

**2912**-нь албан байгууллага

Нийт шуудангийн хайрцагны 45% нь орон нутагт, үлдсэн 55% буюу 20445 ширхэг хайрцаг хотод байна.

## ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ

Хэрэглэгчдэд орцны, хэрэглэгчийн, гудамжны гэсэн 3 төрлийн шуудангийн хайрцгаар үйлчилж, түүгээр дамжуулан хэрэглэгчийг шуудангийн хаягтай болгож, гадаад дотоодтой шуудан харилцаагаар чөлөөтэй харилцах болон хэвлэл захиалан унших боломжийг олгодог.

"Ухаалаг шуудангийн хайрцаг" төслийн хүрээнд хэрэглэгчийг нууц код болон цахим үнэмлэх, хурууны хээгээр таньж шуудангийн илгээмжийг гардуулах зориулалт бүхий програмаар програмчлагдсан, 717 сая төгрөгийн өртөгтэй, тус бүр нь 50 нүд бүхий 20 ширхэг орчин үеийн ухаалаг шуудангийн хайрцгийг УБ хотын 18, Дархан, Эрдэнэт хотуудад тус бүр 1 байршилд байрлуулж, 3-р сарын 06-наас эхлэн үйл ажиллагааг нь эхлүүлсэн ба энэ хугацаанд уг хайрцгийг суурилуулах, турших, ашиглалт, эргэлтэнд оруулах, хэрэглэгчдийг сургах гэх мэт ажлуудыг хийсний үр дүнд 3000 гаруй иргэнд уг шуудангийн хайрцгаар дамжуулан илгээмжийг нь гардуулаад байна.

Шуудангийн хайрцагны орлого компанийн нийт орлогын 1.3%-ийг эзэлдэг.

Шуудангийн хайрцагны орлогыг нэмэгдүүлэх, хайрцагны үйлчилгээг хэрэглэгчдэд таниулахын тулд дараах сайжруулалтыг хийх шаардлагатай.

- Шуудангийн хайрцагны өнгө загварыг сайжруулах
- Шуудангийн хайрцагны загварын катологитой болох
- Хайрцагны ач холбогдолыг хэрэглэгчдэд таниулах, сурталчилах
- Орц, хауст шуудангийн хайрцагийг байршуулах
- Шинэ байрны судалгааг гаргаж шуудангийн хайрцагны загвар хүргүүлэх
- Хайрцагны хураамж төлөлтөнд хяналт тавих
- Шуудангийн хайрцагны нүдний тоо, хэмжээний сонголтуудтай болгох
- Орчин үеийн дэвшилтэт ухаалаг шуудангийн хайрцгийн үйлчилгээг өргөжүүлэх

## ҮНЭТ ЦААСНЫ БОРЛУУЛАЛТ

"Монгол шуудан" ТӨХК нь одоогийн байдлаар 6 төрлийн хэмжээтэй, өнгөний сонголттой дугтуйг жилдээ 600-750 мянган ширхэгийг, шинэ жилийн мэндчилгээг жилдээ 15-20 мянган ширхэгийг үйлдвэрлэж худалдаанд гаргадаг. Үнэт цаасны үйлчилгээний орлого компанийн нийт орлогын 7-8хувийг эзэлдэг бөгөөд бусдын барааг гэрээлэн, алдагдал үүрэн байж борлуулдаг байдлыг зогсоож зөвхөн өөрийн бараа бүтээгдэхүүнийг зарах бодлого барин ажиллаж байна. Үүний хүрээнд урьд өмнө нь нэг бүр нь 150 төгрөгийн өртөгтэй хэвлэгддэг байсан ил захидлыг нэг бүр нь 31-62,5 төгрөгийн өртөгтэй 80 нэр төрлийн 400000 ширхэг ил захидал хэвлэн бүх салбар, газруудаараа борлуулж байна. Уг арга хэмжээг авч хэрэгжүүлсэний үр дүнд бусад хэвлэлийн компаниудын ил захидлуудыг буцаасанаар, компанийн өглөг 30 гаруй сая төгрөгөөр буурч, урьд нь бусдын 150 гаруй төрлийн ил захидлыг борлуулж, жилдээ 2 сая гаран төгрөгийн шимтгэлийн орлого олдог байсан бизнесийг өөрийн болгож, үнэтийн орлогыг нэмэгдүүлжээ.

Монголд зочилж буй жуулчдад Монгол марк, өөрийн үйлдвэрийн ил захидлаа хамгийн ойр байдлаар санал болгох, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд Женко тур, Богдын музей, Динозаврын музей болон Аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, Цонжин болдогт буй Чингисийн морьтой хөшөө, Богдын музей дотор шуудангийн түр салбарыг шинээр байгуулан ажиллуулж марк, ил захидлын борлуулалтыг өсгөсөн байна. Энэхүү үйлчилгээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллах шаардлагатай.

- Компанийн үнэт цаасны борлуулалтын орлогын төлөвлөгөөний дийлэнхийг дугтуйны орлого бүрдүүлж байгаа учраас дугтуйны цаасны хангалтыг таслахгүй байх
- Дугтуйны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Дугтуйны нэр төрлийг олон болгох, чанарыг сайжруулах шаардлагатай
- Тэмдэглэлт баярт зориулсан мэндчилгээ, ил захидал шинээр хийх

## ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Гэсэн хэдий ч 2015 оноос эхлэн Татварын ерөнхий газраас санхүүгийн тайланг цахим хэлбэрээр авч эхэлснээр шуудангаар тайлан хүргэх үйлчилгээ нь цаашид үргэлжлэх боломжгүй болсон байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран 2014.09.01-нээс шүүхийн мэдэгдэх болон шүүх хуралд зарлан дуудах хуудсыг хаягаар хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн ба өнөөдрийн байдлаар 1000 гаруй ширхэг хуудсыг хүргээд байна.

2013 оны сүүлийн хагасаас 2014 онд олон шинэ хүргэлтийн бизнесийн үйлчилгээг нэвтрүүлж ажилласнаар бичиг захидлын солилцоо эрс өсч тэр дундаа гэр хорооллын шуудангийн салбаруудын ачаалал огцом өсч явганаар шуудан хүргэхэд цаг хугацаа их алдаж, хүргэлтийн чанар доголдож байсан учраас Хайлааст, Дамба, Чингэлтэй, зуслангийн хүргэлт, Баянхошуу, Толгойт, Их Наран, Орбитын чиглэлийн хүргэлтэд 3 мопедыг шуудан хүргэлтэд явуулсанаар хүргэлтийн цэгийн тоо, гардуулалтын чанар эрс өссөн үр дүнтэй байна.

Цаашид хүргэлтийн чанарыг сайжруулах, хүргэлтийн чиглэл маршрутыг оновчлох, хугацааг богиносгох, хүргэгчийн харилцааны соёл, үйлчилгээний соёлд анхаарах, хүргэлтийн технологи ажиллагааг цахимжуулах, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

## БУУХИА ШУУДАН (EMS ҮЙЛЧИЛГЭЭ) ИЛГЭЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

"Монгол Шуудан" ТӨХК нь ны EMS буюу буухиа шуудангийн үйлчилгээний корпоративт 1997 онд элсэж, шуудангийн хамгийн шуурхай хэлбэр болох буухиа шуудang цөөн хэдэн оронтой солилцож эхэлсэн ба одоогоор бүх оронтой солилцох боломжтой ч солилцоо ихтэй байдаг 35 оронтой, гадаад энгийн илгээлтийн үйлчилгээг 191 улс оронтой солилцож байна. Буухиа шуудангийн үйлчилгээнээс олж буй орлого нь компанийн нийт орлогын 6-7%-ийг ээлдэг.

## БУУХИА ШУУДАН СОЛИЛЦДОГ УЛСУУДЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ




График 7. Буухиа шуудан солилцдог орны тоон үзүүлэлт

БҮРТГЭВ

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## БУУХИА ШУУДАН

Монгол улсаас жилдээ буухиа шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 5 оператороор дамжин 25-30 мянган ширхэг буухиа шуудан гадаадад гарч байгаа ба мөн тооны илгээмж карго үйлчилгээний компаниуд болон хувь хүнээр дайвраар дамжиж байгаа нь энэхүү зах зээлд өрсөлдөх орон зай, зах зээлээ өргөтгөх боломж асар их байгааг харуулж байна

Үүнээс тус компанийн жилийн буухиа шуудангийн солилцоо 7-8 мянган ширхэг ба нийт зах зээлийн 10-15%-д нь л үйлчилгээгээ хүргэдэг гэж үзэж болохоор байна.

## УЛС ХООРОНДЫН ТООЦОО

"Монгол Шуудан" ТӨХК-ийн хувьд "Улс Хоорондын Тооцоо"-ноос орж ирдэг орлого нь жилд 2 тэрбум гаруй төгрөг болдог бөгөөд энэ нь 2013 онд нийт орлогын 23 хувийг бүрдүүлж байсан бол 2014 онд 22.7 хувийг бүрдүүлсэн байна.

"Улс хоорондын тооцоо"-ны орлого нь манай улсаас гадаад руу явуулсан илгээмжийн хүргэлт гардуулалтанд "Монгол Шуудан" ТӨХК-ийн төлөх төлбөр ба гадаад улсаас Монгол улс руу явуулсан илгээмжийг хүргэж гардуулсны төлөө бусад улсаас "Монгол Шуудан" ТӨХК-д төлдөг төлбөрийн зөрүүгээр тооцогддог орлогын эх үүсвэр тул энэхүү орлогыг цаашид нэмэгдүүлэхийн тулд гадаадаас манай улс руу чиглэсэн шуудангийн эрэлтийг нэмэгдүүлэхэд онцгой анхааран улс хоорондын үйлчилгээний хурд, чанарыг сайжруулж ажиллах шаардлагатай байгаа юм.

"Монгол Шуудан" ТӨХК-ийн 2013-2014 онуудын нийт орлогын эх үүсвэрийн 28%-30%-ийг "Илгээлт, Албан бичиг хүргэлт, Буухиа шуудан"-гийн үйлчилгээний орлого эзэлж байгаа бөгөөд үүн дээр эдгээр үйлчилгээг даган орж ирдэг "Улс хоорондын тооцоо"-ны орлогыг нэмбэл эдгээр үйлчилгээ нь нийт орлогын 50% - 54% буюу дийлэнхийг бүрдүүлдэг хэмээн тооцож болох юм.

Компани нь хэдийгээр 20 төрлийн үйл ажиллагаа явуулдаг боловч үндсэн 6 үйлчилгээнээс бусад нь орлогод бага хувь эзэлж байна. "Монгол Шуудан" ТӨХК-ийн нийт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ОРЛОГЫН БҮТЭЦ

| № | ОРЛОГЫН ТӨРӨЛ | 2014Б /Сая. төг/ | НИЙТ ОРЛОГОД ЭЗЛЭХ % |
|---|---|---|---|
| 1 | МАРК БОРЛУУЛСНЫ ОРЛОГО | 806.61 | 7.25% |
| 2 | ҮНЭТ ЦААСНЫ ОРЛОГО | 290.39 | 2.61% |
| 3 | БАТАЛГААНЫ ОРЛОГО | 292.43 | 2.63% |
| 4 | ЗЭЭЛ АЛБАН БИЧГИЙН ОРЛОГО | 1,096.27 | 9.85% |
| 5 | БООДЛЫН ОРЛОГО | 284.63 | 2.56% |
| 6 | ИЛГЭЭЛТИЙН ОРЛОГО | 1,188.95 | 10.68% |
| 7 | БУУХИА ШУУДАНГИЙН ОРЛОГО | 723.94 | 6.51% |
| 8 | ШУУДАНГИЙН ХАЙРЦАГНЫ ОРЛОГО | 151.12 | 1.36% |
| 9 | ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 1,058.84 | 9.51% |
| 10 | ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ОРЛОГО | 367.75 | 3.30% |
| 11 | ИЛГЭЭМЖИЙН БАРААНЫ ШИМТГЭЛИЙН ОРЛОГО | 146.12 | 1.31% |
| 12 | ХЭВЛЭЛИЙН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО | 651.93 | 5.86% |
| 13 | ХЭВЛЭЛИЙН ХҮРГЭЛТИЙН ОРЛОГО /ЖИНГИЙН/ | 444.15 | 3.99% |
| 14 | УЛС ХООРОНДЫН ТООЦОО | 2,475.27 | 22.24% |
| 15 | ЛОГИСТИК | - | 0.00% |
| 16 | БУСАД | 1,149.93 | 10.33% |
| 17 | НИЙТ ОРЛОГО | 11,128.33 | 100.00% |
| 18 | БУЦААЛТ ХӨНГӨЛӨЛТ | (187.32) | |
| 19 | ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО | 10,941.01 | |

Эх сурвалж: Монгол Шуудан ТӨХК

Хүснэгт 23. "Монгол Шуудан" ТӨХК-ийн орлогын эх үүсвэр

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## КОМПАНИЙН 2012-2014 ОНД УЛСАД ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2012 ОН | 2013 ОН | 2014 ОН |
|---|---|---|---|---|
| 1 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛД | 639 564 000 | 775 085 000 | 960 426 000 |
| 2 | ААН-ИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРТ | 77 227 000 | 46 073 000 | 90 550 000 |
| 3 | ТӨРИЙН ӨМЧИЙН НОГДОЛ АШИГТ | 211 341 400 | 88 357 000 | 40 620 000 |
| 4 | ХХОА-ЫН ТАТВАРТ | 224 900 000 | 186 253 000 | 362 108 000 |
| 5 | НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРТ | 156 500 200 | 244 794 000 | 686 287 000 |
| | **НИЙТ ДҮН** | **1 309 505 600** | **1 340 562 000** | **2 140 000 000** |

Хүснэгт24. Улсад төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ

## УЛСАД ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ \ТӨГ\




График 8. Улсад төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ:

- Шуудан холбоо нь материаллаг биет зүйлсийг дамжуулах үндсэн үйлчилгээнээс гадна бараа, бүтээгдэхүүн /шуудангийн марк, дугтуй, ил захидал, хайрцаг, илгээлтийн сав, баглаа боодол зэрэг/ үйлдвэрлэж борлуулдаг тул үйлдвэрлэл, үйлчилгээний хоёрдмол шинжтэй салбарт тооцогддог.
- Шуудан холбооны сүлжээ /өртөө/ нь орчин үеийн цахилгаан холбоо болон интернэтийн сүлжээний анхдагч загвар гэж үзэж болох бөгөөд орчин үед мэдээллийн технологи, интернэтийнололт нь шуудан холбооны үйлчилгээнд өргөнөөр ашиглагдаж байна.
- Шуудан холбооны сүлжээг харилцаа холбооны бусад төрлийн сүлжээтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын зардал харьцангуй багатай учир үйлчилгээний үнэ тариф харьцангуй бага байдаг. Өөрөөр хэлбэл шуудан холбооны ашиглалтын зардалд тогтмол зардал дийлэнхи хувийг эзэлдэг тул шуудангийн солилцооны тоо өсөхийн хэрээр өөрийн өртөг хямдрах боломжтой юм.
- Шуудан холбооны үйл ажиллагаа нь гадаад хүчин зүйлийн нөлөөлөлд /гадны тээврийг эс тооцвол/ бага өртөмтгий, энэ хэрээр найдвартай ажиллагаа өндөртэй байдаг.
- Шуудангийн үйлчилгээний чанар болон эдийн засгийн үр ашиг нь техник, технологи төдийгүй хүний нөөц, удирдлагын чадвараас ихээхэн хамааралтай байдаг.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.8 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХОЛБОГДОХ ЭТГЭЭД

Монгол Шуудан" ТӨХК нь өөрийн үйл ажиллагааны онцлог шинжээс хамаарч Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй нийт 60 мянга орчим аж ахуй нэгж, албан байгууллагуудаас 35 мянга орчим аж ахуй нэгж, байгууллагуудтай байнгын харилцаатай байж тэдний итгэл хүндэтгэлийг хүлээсэн найдвартай түргэн шуурхай үйлчилгээгээр хангаж ажилласаар байна.

Компанийн харилцагч байгууллагуудын хувьд тэгш эрхтэй бөгөөд 2013 оны 05 сарын 24-ны өдөр батлагдсан "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 4.1.30 дугаарт заасан "Холбогдох этгээд" –ээр тодорхойлогдох хуулийн этгээд болон хувь хүн, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, хараат болон охин компани нь Монгол Шуудан ТӨХК-ийн хувьд байхгүй байна.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.9 АУДИТЫН ДҮГНЭЛТ

"Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК нь Монгол Шуудан ТӨХК-ийн 2015 оны 9-р сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланд аудит хийсэн. Аудитын компаны дүгнэлт нь:

Бидний аудитлагдсан санхүүгийн тайлан нь "Монгол шуудан" ТӨХК-ийн 2015 оны 09-р сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдал,тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь НББОУС-д нийцсэн тайлан гаргах шаардлага, Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө болон түүний үр ашигт байдлыг хангаж байна.

**Санхүүгийн байдлын тайлан**

2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар

| | Тэм | 2014 | 2015 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгөн хөрөнгө | 3 | 2,907,833.3 | 1,773,685.1 |
| Авлага | 4 | 2,523,901.9 | 3,403,004.6 |
| Бараа материал | 5 | 1,570,796.6 | 1,641,895.3 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо / | 6 | 275,537.5 | 208,166.1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 7,278,069.2 | 7,026,751.1 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө,цэвэр | 7 | 8,585,668.9 | 8,338,203.0 |
| Биет бус хөрөнгө | 8 | 285,226.0 | 267,323.0 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 9 | 500.0 | 500.0 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 8,871,394.9 | 8,606,026.0 |
| Нийт хөрөнгийн дүн | | 16,149,464.1 | 15,632,777.1 |
| Өр төлбөр | | | |
| Богино хугацаат өглөг | 10 | 1,307,050.2 | 1,450,678.2 |
| Цалингийн өглөг | | 400.1 | 804.1 |
| НДШ-ийн өглөг | | 33.8 | 2,296.6 |
| Татварын өглөг | | 21,263.5 | 35,358.9 |
| Хүүний өглөг | | - | - |
| Бусад өглөг | | 186,968.4 | 91,336.5 |
| Урт хугацаат зээл | | - | - |
| Урьдчилж орсон орлого | | 708,261.8 | 291,523.5 |
| Өр төлбөрийн нийт дүн | | 2,223,977.8 | 1,871,997.8 |
| Өмч /төрийн / | 11 | 6,572,700.0 | 6,572,700.0 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 12 | 3,379,919.5 | 3,379,919.5 |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | | 2,724,469.0 | 2,750,469.0 |
| Хуримтлагдсан ашиг, (алдагдал) | | 1,248,397.8 | 1,057,690.8 |
| Тайлангийн үеийн | 13 | 671,847.4 | (190,707.0) |
| Өмнөх үеийн | 13 | 576,550.4 | 1,248,397.8 |
| Өмчийн дүн | | 13,925,486.3 | 13,760,779.3 |
| Нийт өр төлбөр, өмчийн дүн | | 16,149,464.1 | 15,632,777.1 |

Эх сурвалж: "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК

Хүснэгт25. Баланс

GAULI INVESTMENT SECURITIES

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

**Дэлгэрэнгүй орлогийн тайлан**
2015 оны 09 дүгээр сарын 30-наар дуусгавар болсон жилийн хувьд

| | Тэм | 2014 | 2015 |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 14 | 10,941,011.8 | 7,199,241.0 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | 9,597,942.3 | 6,835,050.7 |
| Нийт ашиг | | 1,343,069.5 | 364,190.3 |
| Бусад орлого | | - | 40,966.9 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 15 | 517,836.8 | 367,076.8 |
| Ханшийн зөрүүгийн олз гарз | | 51,882.8 | 7,361.6 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз | | 29,815.8 | 63.6 |
| Бусад ашиг /алдагдал/ | | (77,600.8) | (68,900.9) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | 829,330.5 | (23,458.3) |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 16 | - | - |
| Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал) | | 829,330.5 | (23,458.3) |
| Орлогын албан татвар зардал | 17 | 90,486.6 | 4,948.1 |
| Цэвэр ашиг (алдагдал) | | 738,843.9 | (28,406.4) |

Эх сурвалж: "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК

Хүснэгт26. Орлогын тайлан

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.1.10 БИЗНЕС БА ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

"Эвиденсе" ХХК нь үнэлгээний тайлангийнхаа 2-р бүлэгт Монгол шуудан ТӨХК-ийн балансад санхүүгийн шинжилгээ хийн, дүгнэлт гаргаж, 3-р бүлэгт зах зээлийн жишиг үнийн хандлага, цэвэр хөрөнгөнд суурилсан хандлага, орлого капиталжуулалтын хандлагад суурилсан бизнесийн үнэлгээг тус тус тодорхойлжээ. "Эвиденсе" ХХК-ийн дүгнэлт нь:

**Зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэлгээ нь:**

1. Саявтархан /ойрын 3 сард/ зах зээлд борлогдсон ижил төстэй бизнес байгаагүй.
2. Харьцуулагдаж буй компаниуд эрхлэх үйл ажиллагааныхаа чиглэлээр ойролцоо ч зах зээлд эзлэх хувь, үзүүлж байгаа үйлчилгээний нэр төрөл, үйлчилж байгаа зах зээлийн хамрах хүрээ, бүх нийтийн үйлчилгээний үүрэг, үйл ажиллагаа явуулсан хугацаа, ажилчдын тоо, хуримтлуулсан туршлага, өмчийн хэлбэр, байршил зэргээрээ харьцуулагдашгүй юм.
3. Тус компани олон нийтэд хувьцаагаа арилжаалдаг нээлттэй компани бус тул зах зээлийн жишиг үнийн аргад ашигласан үржүүлэгчдийг ашиглан үнэлгээг үндэслэлтэй гэж үзэх боломжгүй байна.
4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн үржүүлэгч нь компанийн бизнесийн үйл ажиллагааг хангалттай хэмжээнд төлөөлж чадах үзүүлэлт болохгүй.

Дээрх шалтгаануудын улмаас хангалттай нотолгоогүй учир зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэлгээг ашигласангүй.

Балансын цэвэр активд суурилсан хөрөнгийн үнэлгээ нь голдуу санхүүгийн тайлагнал болоод бодит хөрөнгийг тодорхойлох зориулалтаар ашиглагддаг, харин тухайн хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд олохоор хүлээгдэж байгаа цэвэр ашиг болон цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцсон бизнейийн үнэлгээ нь хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглагдах нь түгээмэл байдаг.

**Үнэлгээний хандлага бүрээрх хөрөнгийн үнэ цэнийг нэгтгэн хүснэгтээр харуулбал:**

| БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ | |
|---|---|
| БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗАМ | ТУХАЙЛСАН ҮНЭ ЦЭНЭГ |
| ОРЛОГО КАПИТАЛЖУУЛАЛТЫН ХАНДЛАГА | 18,423,477.56 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨД СУУРИЛСАН ҮНИЙН ХАНДЛАГА | 17,282,278.26 |
| ЗАХ ЗЭЭЛИЙН ЖИШИГ ҮНИЙН ХАНДЛАГА | 17,176,642.76 |
| БИЗНЕСИЙН ҮНЭ ЦЭНЭ | 18,423,477.56 |

Эх сурвалж: Эвиденсе ХХК

Хүснэгт27. Бизнесийн үнэлгээний нэгтгэл

Энэ түгээмэл жишиг болон захиалагчийн хийлгэж байгаа үнэлгээний зориулалтыг харгалзан Монгол шуудан ТӨХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ "Орлогын хандлага"-аарх үнэлгээгээр авав. Ийнхүү Монгол шуудан ТӨХК-ийн 2015 оны 09 дүгээр сарын 30-ны үнэлгээний өдрөөрх бизнесийн үнэ цэнийг 18,423,477.56 мянган төгрөг (Арван найман тэрбум дөрвөн зуун хорин гурван сая дөрвөн зуун далан долоон мянга таван зуун жаран төгрөг) болж байгааг тодорхойлж, үнэлгээний тайлан, түүний хавсралт тооцоог захиалагчид хүргүүлж байна.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.2.1 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү хэсэгт үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн цар хүрээ, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, зарцуулалт, үр ашгийн тооцоог багтаасан болно.

"Монгол Шуудан" ТӨХК нь "Авто замын логистикийн үйлчилгээ"-г үе шаттайгаар нэвтрүүлэх зорилгоор уг төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн үндэслэл:

Тээврийн зардал бүтээгдэхүүний үнэд хүчтэй нөлөөлдөг: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ 62% хувийг импортоор авдаг манай улсын хувьд бүтээгдэхүүний үнэд тээврийн зардал өндөр хувийг эзэлж байна. Энэ нь зардал багатай, найдвартай, түргэн шуурхай, Монголын аль ч аймагт тогтмол тээвэрлэлт хийдэг логистикийн үйлчилгээ Монголд хөгжөөгүйтэй холбоотой юм. Үүнээс үүдэн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өндөр тогтох, хэлбэлзэл их байдаг нь иргэдийн нуруунд нэмэлт ачааг үүрүүлж худалдааны салбарт дарамт учруулдаг. Харин логистик хөгжиснөөр уг асуудал шийдэгдэх юм.

Уламжлалт шуудангийн үйлчилгээний зах зээлийн өсөлт хязгаарлагдмал: Ирэх 3 жилийн хугацаанд уламжлалт шуудангийн үйлчилгээг өргөжүүлж компанийн орлогыг нэмэгдүүлэх боломж харагдаж байгаа ч урт хугацаанд өсөлт хязгаарлагдах эрсдэлтэй байна. Ийм нөхцөлд дэлхийн шуудангийн компаниудын хөгжлийн чиг хандлагыг даган логистикийн үйлчилгээний зах зээлд нэвтрэх нь компанийн хөгжилд өндөр ач холбогдолтой юм. Логистикийн үйлчилгээг эрхэлснээр зөвхөн ачаа тээвэрлэхээс гадна шуудангийн үндсэн үйлчилгээгээ хүргэх өргөн сүлжээ бий болдог давуу талтай. Энэхүү сүлжээг бий болгосноор компани хөдөө орон нутагт тогтмол хүрч үйлчлэх боломж бүрдэж нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа найдвартай биелүүлж чадна.

Авто замын хөгжил: 2012 оноос Монголын засгийн газар бүх аймгуудыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлж 2,967 км авто замын уртыг 2,655 км-ээр нэмж 5,622 км урт болгож чадлаа. Ингэснээр 15 аймаг хатуу хучилттай авто замаар Улаанбаатар хоттой холбогджээ. Дэд бүтцийн энэхүү хөгжил нь "авто замын логистикийн үйлчилгээ"-г орон даяар нэвтрүүлэх боломжийг нээж байна. Цаашид засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогоо үргэлжлүүлэх замаар авто замын сүлжээг өргөтгөх юм.

Төмөр зам бараг бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна: Төмөр зам нь ачаа тээвэрлэх хүчин чадлаа бараг 100 хувь ашиглаж байна. Тодруулбал, 2014 онд 20.9 сая тн ачаа тээвэрлэсэн нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна гэсэн үг. Мөн Монголын босоо тэнхлэгийг огтолсон дан шугамтай төмөр замын сүлжээгээр хөдөө орон нутагт ачаа тээвэрлэн хүргэх боломж хязгаарлагдмал юм. Ийм нөхцөлд авто замын тээвэрлэлт зайлшгүй шаардлагатай болно.

Замын-Үүдийн чөлөөт бүсийн давуу тал: "Монгол Шуудан" ТӨХК нь логистикийн төвийг Замын-Үүдийн чөлөөт бүсэд барих бөгөөд "Чөлөөт бүсийн хууль"-ийн дагуу үл хөдлөх хөрөнгийн татвар, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газар ашигласны хураамжаас чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх олон талын эдийн засгийн давуу талуудтай. Иймээс өрсөлдөгчидтэй үнээр өрсөлдөх боломж нэмэгдэнэ.

Хөрөнгө оруулалтын хэмжээ: Нэмэлт хувьцаа гаргаснаар татан төвлөрүүлэх хөрөнгө нь уг "авто замын логистикийн үйлчилгээ"-ний төслийг амжилттай эхлүүлж олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг бий болгох, цаашид сүлжээгээ өргөтгөх боломжийг нээх юм.

Нийгэмд үзүүлэх эерэг нөлөө, компанийн хөгжлийг шинэ түвшинд гаргаж буй байдал, дэд бүтцийн таатай нөхцөл, байршлийн давуу тал, үйлчилгээний давуу тал зэрэг нь уг төсөл амжилттай хэрэгжих үндэслэл болох юм.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

GAULI INVESTMENT SECURITIES

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ЛОГИСТИК ГЭЖ ЮУ ВЭ? АЧ ХОЛБОГДОЛ

"Монгол Шуудан" ТӨХК-ийн төлөвлөж буй дээрх шуудангийн үйлчилгээг харилцагчдад иж бүрэн байдлаар хүргэхийн тулд "авто замын логистикийн төсөл" хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаа юм. Тэгвэл логистик гэж юу вэ? түүний ач холбогдлын талаар товчхон мэдээлэл өгье.

1960-аад оноос анхны логистикийн талаарх ном, зохиолууд бичигдэж эхэлсэн бөгөөд аливаа аж ахуйн нэгж, улс орны хувьд логистик нь үр ашгаа нэмэгдүүлэх, зардлаа багасгах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх бодитой цөөхөн боломжуудын нэг гэж үзэж эхэлсэн.

Логистик (Logistics) гэж нэрлэгддэг үйлчилгээний салбарыг тээвэр гэсэн ойлголтоор төсөөлөн үзэж, асуудал нь дан ганц хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалдаг гэсэн хандлага манай оронд нийтлэг юм. Үнэн хэрэгтээ зах зээлийн нийгэмд логистикийн салбар нь маш өргөн цар хүрээг хамарсан, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг амин чухал салбар байдаг.

Логистикийн гол асуудал нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, зорилтод нийцүүлэн аливаа түүхий эд, бараа, үйлчилгээ, мэдээлэл, санхүүгийн хөрөнгийг эхлэл цэгээс зорилтот цэг хүртэл хамгийн үр ашигтай шилжүүлэлт ба хадгалалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдмэл процесс юм. Үүнийг нэгтгээд Э.Гросневор Плоумэн логистикийн таван зөвийг "зөв зүйлийг, зөв газарт нь, зөв цагт, зөв нөхцөлөөр, зөв зардлаар" гэж тодорхойлсон байдаг.

Логистик нь эдийн засагт хоёр үндсэн сувгаар голлох үүрэгтэй оролцдог. Үүнд:

• Нэгдүгээрт, логистик нь бизнесийн эдийн засгийн хүчин зүйлстэй харилцан уялдаатай оршдог голлох зардлуудын нэг юм.

• Хоёрдугаарт, логистик нь бүхий л эдийн засгийн гүйлгээний урсгал, шилжилтийг дэмжих үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, бүхий л бараа, үйлчилгээний худалдаанд чухал үйл ажиллагаа юм. Хэрвээ бараа цагтаа очихгүй, эсвэл зөв байршилдаа хүрэхгүй бол ямар ч худалдаа, арилжаа, эдийн засгийн хэлцэл хийгдэхгүй юм.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
ТТГ8037 5217962
УЛААНБААТАР ХОТ



20151211

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## МОНГОЛЫН ЛОГИСТИКИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн банкнаас 2007 оноос эхлэн хоёр жилд нэг удаа "Логистикийн гүйцэтгэлийн индекс"-ийн судалгааг хийдэг болсон. Судалгааны зорилго нь ОУ-ын худалдааны салбарт тулгарч байгаа логистикийн саад бэрхшээлүүдийг ойлгон шийдвэрлэхэд улс орны шийдвэр гаргагчид болон бизнес эрхлэгч нарт туслахад оршдог. 2014 оны судалгаагаар Монгол улс нь 160 орноос 135-д буюу сүүлийн 20 хувьд нь багтаж байна. Уг индексийг нийт 5 үзүүлэлтээр тооцож гаргадаг. Үүнд:

- Хил, гаалийн үйлчилгээний чанар /гааль, хилийн хяналт, мэргэжлийн хяналт, хорио цээр гэх мэт/- хугацаа, хөнгөлөлт, хялбаршуулалт
- Дэд бүтцийн хөгжилтэй хамааралтай худалдаа, тээврийн чанар /порт, төмөр зам, авто зам, мэдээллийн технологийн дэд бүтэц/
- ОУ-ын тээвэр /нийлүүлэлтийг өрсөлдөөнт үнээр зохион байгуулах боломж/
- Логистик үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар /тээврийн оператор, гааль зуучлал/
- Ачаа тээврийн замыг оновчтой сонгох боломж
- Нийлүүлэлт төлөвлөсөн хугацаандаа эзэндээ хүрэх давтамж

| УЛС | ОН | LPI ОНОО | ГААЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | ГААЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖ | ОУ-ЫН ТЭЭВЭР | ЛОГИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР | ТЭЭВРИЙН ЗАМНАЛ | НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУГАЦАА |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ГЕРМАН | 2014 | 4.12 | 4.10 | 4.10 | 4.32 | 3.74 | 4.12 | 4.17 | 4.36 |
| ГОЛЛАНД | 2014 | 4.05 | 3.96 | 3.96 | 4.23 | 3.64 | 4.13 | 4.07 | 4.34 |
| БЕЛГИ | 2014 | 4.04 | 3.80 | 3.80 | 4.10 | 3.80 | 4.11 | 4.11 | 4.39 |
| ИХ БРИТАНИ | 2014 | 4.01 | 3.94 | 3.94 | 4.16 | 3.63 | 4.03 | 4.08 | 4.33 |
| СИНГАПУР | 2014 | 4.00 | 4.01 | 4.01 | 4.28 | 3.70 | 3.97 | 3.90 | 4.25 |
| ШВЕД | 2014 | 3.96 | 3.75 | 3.75 | 4.09 | 3.76 | 3.98 | 3.97 | 4.26 |
| НОРВЕГИ | 2014 | 3.96 | 4.21 | 4.21 | 4.19 | 3.42 | 4.19 | 3.50 | 4.36 |
| ЛЮКСЕМБУРГ | 2014 | 3.95 | 3.82 | 3.82 | 3.91 | 3.82 | 3.78 | 3.68 | 4.71 |
| АНУ | 2014 | 3.92 | 3.73 | 3.73 | 4.18 | 3.45 | 3.97 | 4.14 | 4.14 |
| БНХАУ | 2014 | 3.53 | 3.21 | 3.21 | 3.67 | 3.50 | 3.46 | 3.50 | 3.87 |
| ОХУ | 2014 | 2.69 | 2.20 | 2.20 | 2.59 | 2.64 | 2.74 | 2.85 | 3.14 |
| МОНГОЛ | 2014 | 2.36 | 2.20 | 2.20 | 2.29 | 2.62 | 2.33 | 2.13 | 2.51 |

Хүснэгт 38: Логистикийн гүйцэтгэлийн индекс 2014




График 56. Логистикийн гүйцэтгэлийн индекс




График 57. Монголын логистикийн гүйцэтгэлийн үнэлгээ
Эх сурвалж: Дэлхийн банк

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Судалгааны үр дүнгээр Монголын логистикийн гүйцэтгэлийн индекс 2.5 байгаа нь хангалтгүй байгааг илтгэж байна. Нарийвчилан харвал, дотоодын зохион байгуулалтын асуудалтай холбоотой үзүүлэлт хамгийн муу үнэлгээтэй байна. Тодруулбал, тээврийн замнал 2.13 оноо байгаа бол гаалийн үйлчилгээ 2.2, дэд бүтцийн хүртээмж 2.29 гэх мэт. Харин Олон улсын тээврийн үзүүлэлтээр ОХУ-тай ойролцоо байна. Гэхдээ аль ч үзүүлэлт 3-аас бага байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Эндээс маш их анхаарал татаж байгаа үзүүлэлт бол логистикийн гүйцэтгэлийн индексээр БНХАУ 15-д жагсаж байхад ОХУ нь 90-д жагсжээ. Өөрөөр хэлбэл, хөрш орнуудын логистикийн хөгжил сайн байгаа нь манай хөгжилд эерэгээр нөлөөлөх боломжтой гэсэн үг. Иймээс бид дотоодын логистикийн асуудлыг шийдвэрлэх замаар ОХУ болон БНХАУ-ын авто замын транзит ачаа тээврийн үйлчилгээг үзүүлэх бүрэн боломжтой.

"ХҮИ-ийн тооцоонд багтдаг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний сагс дахь нийт 329 төрлийн бараа, үйлчилгээний 265 нь бараа байгаагаас 62%-ийг импортын бараа, бүтээгдэхүүн эзэлж байна. Үүнээс гадна дотоодын бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийн зардалд хүчтэй нөлөөлдөг, нефтийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн орц, тоног төхөөрөмж нь нийт импортын харгалзан 24%, 28%-ийг эзэлдэг" гэж Монгол банкны Валют эдийн засгийн хэлтсийн бодлогын судалгаанд дурьджээ.

Жишээ нь, 2012 оны 8 дугаар сарын байдлаар Замын-Үүд хилийн боомт дээрх цагаан будааны хилийн үнэ 819 төг/кг байсан бол УБ хотод кг будаа 1735 төгрөгөөр худалдаалагдаж байна. Элсэн чихрийн хувьд хилийн үнэ 669 төг/кг бол УБ хотод 1735 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Дээрх дүгнэлтээс харахад манай улсад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өндөр, хэлбэлзэл ихтэй байгаагийн үндсэн суурь шалтгаануудын нэг нь логистикийн хөгжил сул байгаатай холбоотой юм.

Иймээс "Монголын Шуудан" ТӨХК нь эхний шатанд "авто тээврийн логистик төв"-ийг Замын-Үүдийн чөлөөт бүсэд байгуулах замаар Замын-Үүд-Улаанбаатар, Замын-Үүд-Хөдөө орон нутагт, Улаанбаатар-Хөдөө орон нутгийн хооронд логистикийн үйлчилгээ үзүүлэх боломжтой гэж үзэж байна. Энэ төслийг хэрэгжүүлснээр зөвхөн ачаа тээвэрлэхээс гадна и-худалдааны хүргэлт, карго хүргэлт, дайварын хүргэлт гэх зэрэг шуудангийн үйлчилгээг орон даяар хүргэх боломж илүү нээгдэх юм.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11



# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА




График 58. Монгол улсын ачаа тээвэр




График 59. Тээврийн орлого

Монголд төмөр замын сүлжээ хангалттай хөгжөөгүйгээс улбаалан ачаа тээврийн 64 хувь нь авто замаар хийгдэж байна. Мөн төмөр зам нь ачаа тээврийн хүчин чадлаа бараг бүрэн ашиглаж байгаа тухай УБТЗ-аас мэдээлжээ. Ийм нөхцөлд ачаа тээврийн өсөлт нь авто замын тээврийн өсөлтийг нэмэгдүүлэх юм. Мөн нөгөө талаас МУ-ын Засгийн Газар 2012 оноос хойш нийтдээ 2,655 км хатуу хучилттай авто замыг тавьснаар бүх аймгийн төвүүд Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдон, нийт 5,622 км авто замтай болсон тухай Зам Тээврийн Яамнаас мэдээлжээ

Монголын ачаа тээврийн орлогын 36%-ийг авто замаар тээвэрлэсэн ачааны орлого бүрдүүлж байна. Цаашид ачаа тээврийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр авто замын тээврийн орлогын хэмжээ өсөх боломжтой.

## 2014 ОНЫ НИЙТ АЧАА ТЭЭВЭР 58.6 САЯ.ТН

| АВТО ЗАМ | | | | ТӨМӨР ЗАМ | | | | БУСАД /АГААР, УСАН ЗАМ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37.6 САЯ.ТН | | | | 20.9 САЯ.ТН | | | | 0.10 САЯ.ТН |
| УЛС ХООРОНД | 22.3 | ДОТООД | 15.3 | УЛС ХООРОНД | 10.5 | ДОТООД | 10.4 | |
| НҮҮРС | 17.17 | | | ИМПОРТ | 2.31 | | | |
| ТӨМРИЙН ХҮДЭР | 1.78 | | | ЭКСПОРТ | 6.20 | | | |
| ГАЗРЫН ТОС | 0.89 | | | ТРАНЗИТ | 2.00 | | | |
| ЗЭСИЙН БАЯЖМАЛ | 0.67 | | | | | | | |
| ИМПОРТ | 1.78 | | | | | | | |

Эх сурвалж: Зам тээврийн яам

Хүснэгт 39: 2014 оны нийт ачаа тээвэр

Эндээс харахад төмөр замын ачаа тээвэрлэлт 20.9 сая.тн-д хүрсэн байгаа нь хүчин чадлаа бүрэн ашиглаж байгааг илтгэж байгаа бөгөөд импортын бүтээгдэхүүнийг авто замаар тээвэрлэсэн хэмжээ 1.78 сая тн байна. Харин одоо импортын барааны бүтцэд шинжилгээ хийж үзье.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ
20151211

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА




График 60. Импортын барааны бүтэц

2014 онд 5.236 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнийг Монгол улс худалдан авсан бол үүний 3.32 тэрбум нь гол нэрийн бүтээгдэхүүнүүд байна. Харин биет хэмжээсээр нь задлавал 4.86 сая тн, 2.4 тэрбум ширхэг, 30.87 сая.литр, 4.09 сая м2, 14.4 сая хос бүтээгдэхүүн импортложээ.




График 61. Импортын барааны хэмжээ

Нийт импортоос өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импорт 2014 онд 422 мянган тн-д хүрсэн байна. Энд архи, согтууруулах ундаа, ус, ундааны импортыг оруулаагүй.

Хамгийн өндөр дүнтэй нь гурил будаа буюу 97.94 мянган тн байгаа юм.

Харин хилээр нэвтэрч буй байдлаар нь задлан харвал хойд хилээр дээрх импортын 45%, урд хилээр мөн 55% нь нэвтэрчээ.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## ТУХАЙН ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХОЙД ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХУВЬ:




График 62. Хойд хилээр нэвтэрч буй бүтээгдэхүүний хэмжээ

Хойд хилээр гурил, буудай, талх, талхан бүтээгдэхүүн төлхүү нэвтэрч байна. Бүтээгдэхүүний гарал үүслээр нь харвал ОХУ, Европын холбооны 40 орчим улсаас нийлүүлэгджээ.

## ТУХАЙН ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УРД ХИЛЭЭР НЭВТЭРЧ БУЙ ХУВЬ:




График 63. Урд хилээр нэвтэрч буй бүтээгдэхүүний хэмжээ

СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01



# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Урд хилээр хүнсний ногоо, тос, самар, мах, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн төлхүү нэвтэрч байна. Гарал үүслээр нь харвал 170 орчим улсаас нийлүүлэгджээ.

Хэдийгээр манай улс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийхээ 62 хувийг импортоор авдаг ч нэгдсэн байдлаар найдвартай, богино хугацаанд, зардал багатайгаар тээвэрлэх логистикийн үйлчилгээ өдгөө хүртэл бий болоогүй байна. Мөн эдгээр ачааг УБ хотоос хөдөө орон нутаг, бусад хотуудад хүргэх логистикийн үйлчилгээ хомс байгаа юм. Иймд компани нь дэлхийн шуудангийн салбарын чиг хандлагыг дагаж авто замын логистикийн үйлчилгээ үзүүлэх нь компанийн хувьд стратегийн ач холбогдолтой үйл ажиллагаа болно.

“Монгол Шуудан” ТӨХК нь эхний шатанд зөвхөн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн тээвэрлэнэ. Нийт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний 45% нь хойд хилээр, 55% нь урд хилээр нэвтэрсэн байсныг өмнө дурьдсан. Тэгвэл хойд хилээр нэвтэрсэн бүтээгдэхүүний бүтцийг харахад 50 хувь нь төмөр замаар тээвэрлэгдсэн байх магадлалтай байна. Харин урд хилээр нэвтэрсэн бүтээгдэхүүний бүтцийг харахад 40 хувь нь төмөр замаар тээвэрлэгдсэн байх магадлалтай байна.
Эндээс тооцвол Алтанбулагаас Улаанбаатар хүртэл 94.5 мян.тн, Замын-Үүдээс Улаанбаатар хүртэл 139.8 мянган.тн бараа авто замаар тээвэрлэгдсэн байна.

## УГ СТАТИСТИКТ ҮНДЭСЛЭН УЛС ХООРОНДЫН ТЭЭВРИЙН ОРЛОГЫГ ТООЦООЛБОЛ:

| ЧИГЛЭЛ | ЗАЙ-КМ | ҮНЭ - 1КМ/ТН | ХЭМЖЭЭ - ТН | ЗАХ ЗЭЭЛ |
|---|---|---|---|---|
| АЛТАН БУЛАГ-УЛААНБААТАР | 343.00 | 180.00 | 94,500.00 | 5,834,430,000.00 |
| ЗАМЫН-ҮҮД-УЛААНБААТАР | 662.00 | 180.00 | 139,800.00 | 16,658,568,000.00 |
| | НИЙТ | | | 22,492,998,000.00 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Зах зээлийн хэмжээг харгалзан үзсэнээр “Монгол Шуудан” ТӨХК нь эхний ээлжинд зөвхөн Замын-Үүд Улаанбаатарын чиглэлд авто замын логистикийн үйлчилгээг үзүүлнэ.

## ДОТООДЫН АВТО ЗАМЫН АЧАА ТЭЭВРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Нарантуул худалдааны төвөөс хөдөө орон нутагт ачаа тээвэрлэлт хийдэг 20 жолоочоос судалгаа авахад өдөрт аймаг бүр лүү дунджаар 25 тн орчим ачаа гардаг ба зарим өдөр огт гарахгүй зарим өдөр 30-40 тн оор гардаг гэж хариулсан бөгөөд үнийн хувьд дараах байдлаар үйлчилгээ үзүүлдэг байна. Гэхдээ тогтсон хатуу үнэ гэж байхгүй бөгөөд ачаа ихтэй үед үнэ өсдөг, ачих машин олон үед үнэ буурдаг. Жолооч нарын өгсөн мэдээлэлд үндэслэн жилийн 292 хоногт ачаа тээвэрлэдэг гэвэл 14.995 тэрбум төгрөгийн /51.355 сая.төгрөг * 292 хоног/ дотоодын жижиглэн барааны тээврийн зах зээл байна. Гэхдээ “Монгол Шуудан” ТӨХК нь эхний шатанд уг зах зээлрүү шууд нэвтрэхгүй. Эхний шатанд зөвхөн Замын–Үүд Улаанбаатар болон Замын-Үүдээс хөдөө орон нутаг гэсэн чиглэлд логистикийн үйлчилгээ үзүүлнэ.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES
УЛААНБААТАР ХОТ
20131211

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

| № | ЧИГЛЭЛ | | ЗАЙ/КМ/ | 1 ТН АЧААНЫ ҮНЭ-ТӨГРӨГ | 25 ТН АЧАА |
|---|---|---|---|---|---|
| 1 | УЛААНБААТАР | АРХАНГАЙ | 465 | 80,000 | 2,000,000 |
| 2 | УЛААНБААТАР | БАЯНХОНГОР | 640 | 110,000 | 2,750,000 |
| 3 | УЛААНБААТАР | БАЯН-ӨЛГИЙ | 1760 | 334,400 | 8,360,000 |
| 4 | УЛААНБААТАР | БУЛГАН | 330 | 100,000 | 2,500,000 |
| 5 | УЛААНБААТАР | ГОВЬ-АЛТАЙ | 1005 | 201,000 | 5,025,000 |
| 6 | УЛААНБААТАР | ГОВЬ-СҮМБЭР | 230 | 48,300 | 1,207,500 |
| 7 | УЛААНБААТАР | ДУНДГОВЬ | 260 | 44,200 | 1,105,000 |
| 8 | УЛААНБААТАР | ДАРХАН | 219 | 30,000 | 750,000 |
| 9 | УЛААНБААТАР | ДОРНОГОВЬ | 456 | 79,800 | 1,995,000 |
| 10 | УЛААНБААТАР | ДОРНОД | 655 | 124,450 | 3,111,250 |
| 11 | УЛААНБААТАР | ЗАВХАН | 984 | 130,000 | 3,250,000 |
| 12 | УЛААНБААТАР | ОРХОН | 371 | 81,620 | 2,040,500 |
| 13 | УЛААНБААТАР | ӨВӨРХАНГАЙ | 430 | 77,400 | 1,935,000 |
| 14 | УЛААНБААТАР | ӨМНӨГОВЬ | 553 | 102,305 | 2,557,625 |
| 15 | УЛААНБААТАР | СҮХБААТАР | 560 | 106,400 | 2,660,000 |
| 16 | УЛААНБААТАР | СЭЛЭНГЭ | 335 | 65,325 | 1,633,125 |
| 17 | УЛААНБААТАР | ТӨВ | 45 | 9,000 | 225,000 |
| 18 | УЛААНБААТАР | УВС | 1336 | 100,000 | 2,500,000 |
| 19 | УЛААНБААТАР | ХОВД | 1580 | 100,000 | 2,500,000 |
| 20 | УЛААНБААТАР | ХӨВСГӨЛ | 671 | 100,000 | 2,500,000 |
| 21 | УЛААНБААТАР | ХЭНТИЙ | 330 | 30,000 | 750,000 |
| ӨДӨРТ УЛААНБААТРААС АЙМАГУУД РУУ ТЭЭВЭРЛЭГДЭЖ БУЙ ЖИЖИГЛЭНГИЙН АЧААНЫ ЗАХ ЗЭЭЛ | | | | | 51,355,000 |

Хүснэгт 40: Дотоодын авто замын ачаа тээвэр

## ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ - 2014 ОН

| Зах зээлийн төрөл | | Зах зээлийн хэмжээ тэрбум төгрөг | Тайлбар | эх сурвалжийн | Ашигласан эх сурвалжийн хугацаа |
|---|---|---|---|---|---|
| **Авто замын тээвэр** | **Улс хооронд** | **22.49** | Замын-Үүдээс Улаанбаатар, Алтанбулагаас Улаанбаатар гэсэн хоёр чиглэлд авто замаар тээвэрлэгдэж буй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зах зээлийг судалсан. Үүнд архи согтууруулах ундаа, бүх төрлийн хүнд ба хөнгөн машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материал, электрон бараа, хуванцар сав, уут багтаагүй | -Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэл,<br>-Зам тээврийн яамны тайлан | **2014** |
| | **Дотоодод** | **14.99** | Зөвхөн Улаанбаатараас аймагууд руу тээвэрлэгдэж буй жижиглэн ачааны зах зээлийг судалсан бөгөөд бөөний тээвэрлэлтийн зах зээлийг багтаагаагүй дүн | -Нарантуул захаас хөдөө орон нутагт ачаа тээвэрлэдэг 20 жолоочоос 3 өдрийн турш авсан судалгаа | **2015** |
| Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зах зээл | | **37.48** | | | |

Хүснэгт 41: Зах зээлийн багтаамж 2014

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

| Зах зээлийн төрөл | | Зорилтот зах зээлийн хэмжээ мянган.тн | Зах зээлд нэвтрэх хэмжээ | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Авто замын тээвэр | Улс хооронд | Албантулаг – 94.5 | 0 | 0 |
| | | Замын-Үүд - 139.8 | 27.456 | 20% |
| Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зах зээл | | 37.48 | 0 | 0 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 42: Зах зээлийн багтаамж

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 1

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.2.8 ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү хэсэгт эрсдэлийн хүчин зүйлсийг үүсч буй орчиноос нь гадаад ба дотоод гэж ангиллаа. Ангилалын дагуу компанид учирч болох голлох эрсдэлүүд болон тэдгээрээс хэрхэн зайлсхийх боломжийг тодорхойлсон.

| Эрсдэл үүсч буй орчин | Эрсдэлийн төрөл | Компанид хэрхэн нөлөөлөх вэ? | Тайлбар | Зайлсхийх арга зам | Эрсдэлээс зайлсхийхэд шаардагдах үйл ажиллагааг гүйцэтгэгч |
|---|---|---|---|---|---|
| Гадаад | Макро эдийн засаг | Орлогод аажмаар нөлөөлөх | Макро эдийн засгийн сөрөг нөлөөгөөр компанийн орлого буурах | Макро эдийн засгийн орчныг хагас жил тутамд тодорхойлдог байх | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь өөрсдөө судалгаа хийх эсвэл томоохон судалгааны байгууллагуудын судалгаа тогтмол ашиглах |
| Гадаад | Хууль эрх зүйн орчин | Орлогод огцом нөлөөлөх | Хууль эрх зүйн орчны өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | Мэдээлэл Технологи Шуудан Харилцаа Холбооны газар, Харилцаа Холбооны Зохицуулах газартай нягтхамтран ажиллах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь зохицуулагч байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж, хууль эрх зүйн орчны өөрчлөлт өөрсдийн саналыг оруулах |
| Гадаад | Техник, технологи | Орлогод аажмаар нөлөөлөх | Технологийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | Шуудангийн технологитой холбоотой судалгааг жилд нэг удаа хийдэг байх | Мэдээллийн технологийн хэлтэс нь тогтмол судалгаа хийх |
| Гадаад | Хүн ам зүй | Орлогод аажмаар нөлөөлөх | Хүн ам зүйн өөрчлөлттэй холбоотойгоор компанийн орлого буурах | - | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь хүн ам зүйн судалгааг хийх эсвэл томоохон судалгааны байгууллагуудын судалгааг тогтмол ашиглах |
| | Хэрэглэгчдийн хандлага | Орлогод аажмаар нөлөөлөх | Хэрэглэгчдийн хандлага сөргөөр өөрчлөгдөж компанийн орлого буурах | Хэрэглэгчдийн компанийг үнэлэх үнэлэмж, компанид итгэх итгэлийг нэмэгдүүлэх | Бизнес, маркетингийн хэлтэс нь хэрэглэгчдийн хандлагыг тогтмол судлах |
| Гадаад | Харилцагчтай холбоотой | Орлогод аажмаар tнөлөөлөх | Харилцагчид өөр компаниар үйлчлүүлэх замаар компанийн орлого буурах | Харилцагчид үзүүлж буй үйлчилгээг улам чанаржуулах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь нэг харилцагчийн компанийн орлогод нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг тооцож, цаашид шаардагдах арга хэмжээг тодорхойлох |
| Гадаад | Нийлүүлэгчтэй холбоотой | Орлогод аажмаар нөлөөлөх | Нийлүүлэгчид өөр компаниудад нийлүүлэлт хийснээр компанийн үйл ажиллагаа доголдох орлого буурах | Нийлүүлэгчидтэй урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх, голлох нийлүүлэгчидтэй урт хугацааны гэрээ байгуулах | Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс нь нэг нийлүүлэгчийн компанийн орлогод нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг тооцож, цаашид шаардагдах арга хэмжээг тодорхойлох |
| Гадаад | Зах зээлд өрсөлдөгчид нэвтрэх | Орлогод аажмаар нөлөөлөх | Шинэ өрсөлдөгчид зах зээлд нэвтэрч зах зээлийг хуваах замаар компанийн орлого буурах | Харилцагчдад үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах | Бизнес, маркетингийн хэлтэс нь өрсөлдөгчдийг судлах, шаардагдах арга хэмжээг боловсруулах |
| Гадаад | Бүтээгдэхүүнийг орлуулах | Орлогод аажмаар нөлөөлөх | Хэрэглэгчид бүтээгдэхүүнийг орлуулах замаар компанийн орлого буурах | Хууль эрх зүйн орчныг сайжруулах, чангатгах замаар орлуулах бүтээгдэхүүнийг зах зээлээс шахах, өөрсдийн үйлчилгээний чанарыг сайжруулах | Бизнес, маркетингийн хэлтэс нь өрсөлдөгчдийг судлах, шаардагдах арга хэмжээг боловсруулах |

МОНГОЛ ШУУДАН ТӨХК УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК GAULI SECURITIES Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дотоод | Үйл ажиллагаа | Орлогод огцом нөлөөлөх | Үйл ажиллагааны зохион байгуулалт муутайгаас үүдэн компанийн орлого буурах | Үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчлох, эргэн харах хугацааг хагас жил тутамд хийх | Захиргаа, удирдлагын хэлтэс нь үйл ажиллагааны оновчтой байдлыг үнэлж, шаардагдах арга хэмжээ авах |
| Дотоод | Боловсон хүчин | Орлогод аажмаар нөлөөлөх | Боловсон хүчний дутмаг байдлаас үүдэлтэйгээр компанийн орлого буурах | Чадварлаг боловсон хүчнийг татахад цалин, хангамжийг сайжруулах, хувьцааны давуу талыг ойлгуулах | Захиргаа, удирдлагын хэлтэс нь боловсон хүчний үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг авах |
| Дотоод | Компанийн засаглал | Орлогод аажмаар нөлөөлөхОрлогод аажмаар нөлөөлөх | Компанийн засаглал сул байхаас үүдэн компанийн орлого буурах | Компанийн засаглалын кодексийн дагуу ажиллах | Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийг хуулийн дагуу томилж, ТУЗ нь сайн компанийн засаглалыг компанид нэвтрүүлэх |
| Дотоод | Хөрвөх чадвар | Орлогод огцом нөлөөлөх | Санхүүгийн хөрвөх чадвараа хангаж чадаагүйгээс компанийн орлого буурах | Санхүүгийн шинжилгээг улирал бүр нарийвчлан хийж санхүүгийн төлөвлөлтийг тогтмол хийж байх | Санхүүгийн хэлтэс нь санхүүгийн шинжилгээний дунд ба ахисан түвшиний аргачлалуудыг ашиглан компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах |
| Дотоод | Төлбөрийн чадварын | Орлогод огцом нөлөөлөх | Санхүүгийн төлбөрийн чадвараа хангаж чадаагүйгээс компанийн орлого буурах | | |

Хүснэгт 43: Эрсдлийн шинжилгээ

## ЭРСДЛИЙГ ДААТГАЛЫН КОМПАНИД ШИЛЖҮҮЛЭХ

Өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд цөөн тохиолддог боловч нэг удаагийн хохирол нь өндөр байдаг эрсдэлүүдийг даатгалын компаниудад хуваан байршуулах нь зүйтэй. Автомашин, ачаа, барилга гэх зэрэг биет хэлбэртэй бөгөөд өндөр үнэлгээтэй, эрсдэлд өртвөл хохирол их амсах хөрөнгүүдийг даатгуулах нь зүйтэй.

Даатгалын компанийг сонгохдоо эрсдэл даах чадварын харьцаанууд болон зах зээлд эзлэх хувь, туршлагыг нь харгалзан үзэх нь зүйтэй. Мөн бүх хөрөнгөө даатгалын нэг компанид даатгуулах нь эрсдэлтэй учир хэд хэдэн компанид тараан байршуулах нь эрсдэлийг давхар бууруулах ач холбогдолтой.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES
УЛААНБААТАР ХОТ
20151211

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.2.9 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Монгол улсын "Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулиудад заасан болон компанийн дүрэмд заасан дараах эрхтэй.

- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ноогдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан болович хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсаны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах
- Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах
- Энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргах
- Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр хүргүүлнэ.
- Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 64.6-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.
- Компани нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдийн шаардсанаар түүнд танилцуулах үүрэгтэй.
- Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ

- Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

GAULI INVESTMENT SECURITIES

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:

- Нийлэх нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх
- Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх
- Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES CO.,LTD
УЛААНБААТАР ХОТ

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.2.10 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

"Монгол Шуудан" ТӨХК-ийн дүрэм, "Ногдол ашгийн бодлогын дотоод журам"-д тусгагдсан хувьцаа эзэмшигчдийн эрх болон ногдол ашгийн бодлогын талаарх мэдээллийг оруулж журмын төслийг боловсруулан баталжээ. "Монгол Шуудан" ТӨХК нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалсны дараа хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр сонгож, улмаар компанийн засаглалын журмуудыг дахин хэлэлцэн батлах болно.

### I. ХУУЛЬ ЗҮЙН ФИРМИЙН ДҮГНЭЛТ

- "Монгол Шуудан" ТӨХК-ийн дүрмийг Компанийн тухай хуулийн холбогдох зүйл заалт болон компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулсан байна.
- "Монгол Шуудан" ТӨХК-ийн Компанийн засаглалын 5 журам нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд тус байгууллагын хувьд одоогоор тусдаа журам батлах шаардлагагүй Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмуудыг мөрдлөг болгон ажиллах нь зүйтэй.

### II. КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ДОТООД ЖУРМААС

**Ногдол ашиг хуваарилах тухай**

- Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/- өөс гаргана.
- Компани тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилаж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө санхүүгийн тооцоолол цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулна.
- Компанийн үйл ажиллагааны ашгаас хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- Ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдээлнэ.

Ногдол ашгийн хувь хэмжээ

- Компани нь жил бүрийн тайлант үеийн цэвэр ашгаас 10 хувийг ногдол ашгаар тараана.
- Компани нэг төрлийн хувьцаанд адил тэгш хэмжээний ногдол ашиг хуваарилна.

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

**Ногдол ашиг хуваарилах бодлого**

- Компани дараах нөхцөлд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна.
- Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь "Компанийн тухай" хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх
- Компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх
- Компани эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй
- Компани дараах тохиолдолд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна.
- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
- Компани нь эргүүлэн авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар буурсан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор өөрийн зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

**Хариуцлага**

- Ногдол ашгаа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр компани нь алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг компанийн гүйцэтгэх удирдлага бүрэн хариуцна.

## 2.2.11 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЛААР

Компани нь олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 10.8.1 -т заасны дагуу "Одгэрэл энд Партнерс" ХХН хууль зүйн компанитай 2015 оны 11 сарын 10-ны өдөр хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажилласан билээ.

Уг гэрээний дагуу хууль зүйн компани нь "Монгол Шуудан" ТӨХК-аас ирүүлсэн 01/484 тоот албан бичигт үндэслэн дараах чиглэлээр хөндлөнгийн дүгнэлт гаргасан байна.

Энэ талаар хууль зүйн дүгнэлтэд: "Монгол улсын Иргэний хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1-д заасан ... Их хэмжээний хэлцэл мөн түүнчлэн, Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д заасан .... сонирхлын зөрчилтэй хэлцэл сүүлийн 1 жилийн хугацаанд хийгдээгүй байна." хэмээн дүгнэжээ.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

GAULI INVESTMENT SECURITIES

# ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## 2.3 АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА

“ГАУЛИ ҮЦК” ХХК нь 2008 онд байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол-Солонгосын хамтарсан компани юм. Манай компани нь өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулахдаа 2009 онд Ремикон ХК-ийн ерөнхий андеррайтераар ажиллан 1.5 тэр бум төгрөгийг татан төвлөрүүлсэн, 2012 онд “Өв ханын материал” ХК-ийн хяналтын багцыг хөрөнгө оруулагч худалдан авах үйл ажиллагааны андеррайтер компаниар ажиллаж компанийн бүртгэлийг сэргээх, компанийн үйл ажиллагааг өөрчлөх, шинэ хяналтын багц эзэмшигчийг зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан нь одоогийн “Глобал монголиа холдингс” ХК болно.
“ГАУЛИ ҮЦК” ХХК нь 2008 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 250 сая төгрөг байсан бол өдгөө 763 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд цаашид хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхээр зорьж ажиллаж байна.
“Монголын ард түмэнд үнэт цаасны зах зээлийг таниулах” гэсэн алсын зорилготой байгуулагдсан манай компани энэхүү зорилгынхоо хүрээнд 2009 - 2015 онд нийт 5,000 орчим хүмүүст 100 гаруй удаагийн үнэт цаасны зах зээлийн ач холбогдлын талаарх сургалт, семинарыг өөрийн зардлаар зохион байгуулсан байна. Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос зохион байгуулсан зах зээлийг хөгжүүлэх, иргэд ба харилцагчдыг үнэт цаасны зах зээлийн талаарх мэдээлэл зөвлөгөөгөөр хангах үйл ажиллагаанд ямагт идэвхитэй оролцож ирсэн билээ.

## БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ

GAULI INVESTMENT SECURITIES

**ГАУЛИ ҮЦК ХХК**
Андеррайтер, Брокер
Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
Монголын Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8- хороо Оюутны гудамж, Сонор Плаза 602,
www.gauli.mn

| Үнэт цаасны материалтай холбогдуулан мэдээлэл өгөх хариуцлагатан | | |
|---|---|---|
| Байгууллагын нэр | Монгол Шуудан ТӨХК | ГАУЛИ ҮЦК ХХК |
| Хариуцах ажилтны нэр | Т.Нямдаш | Г.Мөнх-Эрдэнэ |
| Албан тушаал | Хуулийн зөвлөх | Шинжээч |
| Утас | 9901-9858 | 8980-4010 |
| Цахим шуудан | tnyamdash@yahoo.com | Munkh-erdene@gauli.mn |

Хүснэгт 44: Ажилтны мэдээлэл

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ ШУУДАН

*Үзүүргүй хязгаарт өртөөлөн хүргэнэ...*

СЭХ
оч сар өдөр
БҮРТГЭВ

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

ХАВСРАЛТ 1

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**2015 оны 07 сарын 03 өдөр**

**Дугаар 70**

**Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлд заасан хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Батсуурь/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

---

МОНГОЛ ШУУДАН ТӨХК

GAULI SECURITIES Co., Ltd

Монгол Улсын Их Хурлын 2015 оны

70 дугаар тогтоолын хавсралт

# ТӨРИЙН ӨМЧИЙГ 2015-2016 ОНД ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

## НЭГ. ТӨРИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛГО

1.1.Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн зорилго нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцаа, хөрөнгийг хувьчлах замаар хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж, улмаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хувьчлалаас орох орлогыг ашиглан тухайн компани, хуулийн этгээдийн техник, технологийг шинэчлэн сайжруулж, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурийг бий болгоход оршино.

1.2.Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл нь /цаашид “Үндсэн чиглэл” гэх/ салбар тус бүрд байгаа төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийг хувьчлах, өөрчлөн байгуулах талаар хийх ажлын чиглэлийг тодорхойлж байгаа баримт бичиг болно.

## ХОЁР. ХУВЬЧЛАЛ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

2.1.Төрийн өмчийн хувьчлал, өөрчлөн байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг баримтална:

2.1.1.Улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор хувийн хэвшлийн үр өгөөж бүхий хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн оролцоог багасгах эдийн засгийн бүтцийг бий болгох;

2.1.2.Хувьчлал, өөрчлөн байгуулалтыг хууль эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх;

2.1.3.Төрийн өмчлөлөөр дамжуулан зохицуулж байгаа төрийн зохицуулалтын ажиллагааг багасган, зах зээлийн харилцаанд нь шилжүүлэх;

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

## ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА, ХЭЛБЭР, ХУГАЦАА

3.1.Үндсэн чиглэлийг дараах зохион байгуулалттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1.Засгийн газар энэхүү үндсэн чиглэлийн хүрээнд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг жил бүр батлан тэдгээрийг хувьчлах, өөрчлөн байгуулах арга, хэлбэрийг нэг бүрчлэн тогтоон, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Улсын Их Хуралд тайлагнах;

3.1.2.Засгийн газрын баталсан жагсаалтад дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийг хууль тогтоомжийн хүрээнд хувьчлах, өөрчлөн байгуулах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулах ажлыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллага тухайн салбарын яамтай хамтран гүйцэтгэх;

3.1.3.Энэхүү үндсэн чиглэлийг 2015-2016 онд хэрэгжүүлэх бөгөөд төрийн өмчийг хувьчлахдаа хуулийн этгээдийн эдийн засагт эзэлж байгаа байр суурь, үйл ажиллагааны онцлогт тохируулан хувьчлалын уламжлалт арга, хэлбэрийн зэрэгцээ хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд санал болгох, нэмэлт хувьцаа гаргах зэрэг аргыг түлхүү хэрэглэх;

3.1.4.Хувьчлалаас орсон орлогыг тухайн компанийн техник, технологийг шинэчлэн сайжруулахад зарцуулахыг гол болгох;

3.1.5.Хувьчлах хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр хувьчлалыг хэрэгжүүлэх;

3.1.6.Төрийн эзэмшлийн хөрөнгө болон хувьцааг хувьчлан худалдсаны төлбөрийн тодорхой хэсэгт арилжааны банкнаас гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас ашиглах;

## ДӨРӨВ. ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД

4.1.“Дулааны цахилгаан станц-4” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах

4.2.“Дулааны цахилгаан станц-3” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах.

4.3.“Дулааны цахилгаан станц-2” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах.

4.4.“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах.

4.5.“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах.

4.6.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж, бие даасан хуулийн этгээд болгон хувьчлах.

4.7.“Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн захиалгыг үндэслэн диспетчерийн зохицуулалт хийх арилжааны оператор компани болгон өөрчлөн зохион байгуулах

4.8.“Шивээ-Овоо” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар тус компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх.

4.9.“Багануур” хувьцаат компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 51 хувьд байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар тус компанийн нүүрс гаргах хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх

4.10.“Эрдэнэс Таван Толгой” хувьцаат компанийн иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн хувьцааны тоо хэмжээ, бүртгэлийг холбогдох хууль болон Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрүүдэд нийцүүлэн цэгцэлж, хувьцааг нийтэд санал болгон арилжаалах бэлтгэлийг хангах

4.11.“Оргил рашаан сувилал” төрийн өмчит хувьцаат компанид сувиллын лавлагаа, судалгааны үйл ажиллагааг нэмж хариуцуулан зохион байгуулж, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй байх нөхцөлтэйгөөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах

4.12.“Кино урлагийн дээд сургууль” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгож, татгалзсан тохиолдолд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

4.13.“Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд, түүний технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтэд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагч этгээдэд оруулсан хөрөнгөд нь тохируулан нэмэлт хувьцаа гарган эзэмшүүлэн хувьчлах

4.14.“Авто импекс” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааны доод үнэ дээр Сангийн яаманд төлөх төлбөрийг нэмж нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах

4.15.“Монгол шуудан” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах

4.16.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг БНСУ-ын “Корей Телеком” компанид худалдан авахыг санал болгож, татгалзсан тохиолдолд хөрөнгийн зах зээлд нийтэд худалдах

4.17.“Хөтөлийн цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах

4.18.“Төрийн банк” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг арилжих

*/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 102 дугаар тогтоолоор нэмсэн/*

4.19.“Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг хувьчлах.

*/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 102 дугаар тогтоолоор нэмсэн/*

-----oOo-----

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ

ХАВСРАЛТ 2

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2015 оны 8 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 330**

**2015-2016 ОНД ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ыг хавсралт ёсоор батлсугай.

2. Жагсаалтад заасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг холбогдох яамтай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, явц, үр дүнг сар тутам Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж), “Эрдэнэс Монгол” ХХК (Б.Бямбасайхан)-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын зарим байгууллагыг өөрчлөн байгуулах тухай” Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “б” болон 8 дугаар зүйлийн “Кино урлагийн дээд сургууль,” гэснийг тус тус хассугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.САЙХАНБИЛЭГ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2015 оны 330 дугаар

тогтоолын хавсралт

## 2015-2016 ОНД ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Байршил | Хувьчлах хувь, хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа (улирал) | Хувьчлах бэлтгэл ажлын хүрээнд авах арга хэмжээ, хувьчлах арга, хэлбэр, нөхцөл |
|---|---|---|---|---|---|
| 1. | “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК | Улаанбаатар<br>Хан-Уул дүүрэг | Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах |
| 2. | “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК | Улаанбаатар<br>Хан-Уул дүүрэг | Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах |
| 3. | “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК | Улаанбаатар<br>Хан-Уул дүүрэг | Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах |
| 4. | “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК | Дархан-Уул аймаг Дархан сум | Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах |
| 5. | “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК | Орхон аймаг<br>Баян-Өндөр сум | Нийт хувьцааны 70 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд |

СЗХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ашиглах |
| 6. | “Шивээ-Овоо” ХК | Говьсүмбэр аймаг Шивээговь сум | Нийт хувьцааны 51 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд бэлтгэл хангаж,<br><br>2016 онд<br><br>хэрэгжүүлэх | Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлүүлэх:<br><br>-нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох;<br><br>-нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгох эсэхийг шийдвэрлэх.<br><br>Эдгээр арга хэмжээг авсны үндсэн дээр компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх |
| 7. | “Багануур” ХК | Улаанбаатар<br><br>Багануур дүүрэг | Нийт хувьцааны 51 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд бэлтгэл хангаж,<br><br>2016 онд<br><br>хэрэгжүүлэх | Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлүүлэх:<br><br>-нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох;<br><br>-нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгох эсэхийг шийдвэрлэх.<br><br>Эдгээр арга хэмжээг авсны үндсэн дээр компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх |
| 8. | “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК | Улаанбаатар<br><br>Хан-Уул дүүрэг | Цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн цахилгаан эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс салгаж, бие даасан хуулийн этгээд болгон хувьчлах |

УЛААНБААТАР ХОТ
GAULI SECURITIES Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 1

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9. | “Оргил рашаан сувилал” ТӨХК | Улаанбаатар Хан-Уул дүүрэг | 100 хувь хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанид сувиллын лавлагаа, судалгааны үйл ажиллагааг нэмж хариуцуулан зохион байгуулж, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй байх нөхцөлтэйгөөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах |
| 10. | “Кино урлагийн дээд сургууль” ХХК | Улаанбаатар Баянзүрх дүүрэг | Төрийн эзэмшлийн хувьцааг (51 хувь) хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгож, татгалзсан тохиолдолд нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах |
| 11. | “Хөдөө аж ахуйн бирж” ХХК | Улаанбаатар Чингэлтэй дүүрэг | Нийт хувьцааны 34 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд бэлтгэл хангаж, 2016 онд хэрэгжүүлэх | Компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд, түүний технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтэд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагч этгээдэд оруулсан хөрөнгөд нь тохируулан нэмэлт хувьцаа гарган эзэмшүүлэн хувьчлах |
| 12. | "Авто импекс" ХК | Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг | Төрийн эзэмшлийн хувьцааг (51 хувь) хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн төрийн эзэмшлийн хувьцааны доод үнэ дээр Сангийн яаманд төлөх төлбөрийг нэмж нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах |
| 13. | “Монгол шуудан” ТӨХК | Улаанбаатар Чингэлтэй дүүрэг | Нийт хувьцааны 66 хувийг төрийн эзэмшилд үлдээнэ | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах |
| 14. | “Монголын цахилгаан холбоо” ХК | Улаанбаатар Чингэлтэй дүүрэг | Төрийн эзэмшлийн хувьцааг (54.67 хувь) хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Төрийн эзэмшлийн хувьцааг БНСУ-ын “Корей Телеком” компанид худалдан авахыг санал болгож, татгалзсан тохиолдолд хөрөнгийн зах зээлд нийтэд худалдах |
| 15. | “Хөтөлийн цемент шохой” ТӨХК | Сэлэнгэ аймаг Сайхан сум | 100 хувь хувьчлах | 2015 оны IY улиралд хэрэгжүүлэх | Компанийн төрийн эзэмшлийн хувьцааг өр төлбөрийг төлөх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулагч талд санал болгон хувьчлах |

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
ТТГ8037 ☏ 5217962
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

ХАВСРАЛТ 3

МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 09 сарын 28 өдөр Дугаар 594 Улаанбаатар хот

Нэмэлт хувьцаа гаргах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, "Монгол шуудан" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 09/03/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол шуудан" ТӨХК-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг гаргаж, нийтэд анхлан санал болгосугай.

2. Компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, мэргэжлийн байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнэх, сунгах асуудлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /О.Сэр-Од/, Гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.НАНЗАДДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОДМАА

МОНГОЛ ШУУДАН ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК
GAULI SECURITIES Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 4

# "МОНГОЛ ШУУДАН" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 10 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар 10/07/09 | Улаанбаатар хот

Гэрээ байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, Улсын Их хурлын 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 330 дугаар тогтоол, компанийн хувьцаа эзэмшигч Төрийн өмчийн хорооны 2015 оны 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 594 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Монгол шуудан" төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хувьд ногдох хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжаалах бэлтгэл ажлыг хангаж холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсүгэй.

Хоёр. Компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хувьд ногдох хэмжээнд нэмэлт хувьцаа гарган арилжаалах, Андеррайтер-зөвлөх үйлчилгээг Андеррайтер, брокер дилерийн тусгай зөвшөөрөл бүхий "Гаули" хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсүгэй.

Гурав. "Гаули" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай байгуулсан 2012 оны 12/197 тоот гэрээг үнэлж, дүгнэн "Монгол шуудан" төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааны 34 хувьд ногдох хэмжээний нэмэлт хувьцаа гаргах Андеррайтер зөвлөх үйлчилгээний гэрээ хийхийг "Монгол шуудан" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/-д зөвшөөрсүгэй.

МОНГОЛ ШУУДАН ТӨХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ УЛААНБААТАР ХОТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /О.СЭР-ОД/

МОНГОЛ ШУУДАН ТӨХК УЛААНБААТАР ХОТ

ГАУЛИ ҮЦК ХХК GAULI SECURITIES Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ